




САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/114/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.




## АГУУЛГА

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БСГ	Боловсрол соёлын газар





**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН НАСАН  
ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН  
ДАРГА Ж.НАСАНЖАРГАЛ ТАНАА

2025.02.05 № 115

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.


**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайланд онд Боловсрол соёл шинжлэх ухааны яамны хандив тусламжаар 2,550.0 мянган төгрөгийн компьютер, 733.9 мянган төгрөгийн принтер, 2,486.3 мянган төгрөгийн ухаалаг самбар, нийт 5,770.2 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2024 оны



04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн бөгөөд цалингийн зардал 380,824.3 мянган төгрөг болж 16.5 хувиар өссөн байна.

### **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсрол газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР





## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>171,177,698.63</b>	<b>279,577,536.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>158,132,205.63</b>	<b>265,908,293.12</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө	158,132,205.63	265,908,293.12
3121	төгрөг	158,132,205.63	265,908,293.12
31211	Төрийн сангийн харилцах	158,132,205.63	265,908,293.12
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,045,493.00</b>	<b>13,669,243.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>13,045,493.00</b>	<b>13,669,243.00</b>
35410	Бичиг хэргийн материал	658,000.00	904,500.00
35420	Аж ахуйн материал	11,698,393.00	12,075,643.00
35470	Бусад хангамжийн материал	689,100.00	689,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,997,554.64</b>	<b>31,228,304.69</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>36,997,554.64</b>	<b>31,228,304.69</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>36,997,554.64</b>	<b>31,228,304.69</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,871,504.40	44,641,749.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,380,855.56)	(26,941,048.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,875,317.00	31,875,317.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,895,762.08)	(23,875,064.00)
39217	Ном	5,527,350.88	5,527,350.88
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Программ хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>208,175,253.27</b>	<b>310,805,840.81</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>208,175,253.27</b>	<b>310,805,840.81</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	208,175,253.27	310,805,840.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	-	310,805,840.81
51210	Өмнөх үеийн үр дүн	208,175,253.27	208,175,253.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	102,630,587.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>208,175,253.27</b>	<b>310,805,840.81</b>





## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>545,960,039.28</b>	<b>552,785,545.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,835,939.28</b>	<b>5,770,245.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,835,939.28</b>	<b>5,770,245.00</b>
<b>120004</b>	<b>төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>8,789,140.00</b>	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,789,140.00	-
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	46,799.28	5,770,245.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>537,124,100.00</b>	<b>547,015,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>513,928,600.00</b>	<b>545,515,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,928,600.00	545,515,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,195,500.00</b>	<b>1,500,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	23,195,500.00	1,500,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>406,594,954.81</b>	<b>450,154,957.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>406,594,954.81</b>	<b>450,154,957.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>393,501,671.53</b>	<b>450,154,957.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>326,775,493.17</b>	<b>380,824,340.11</b>
210101	Үндсэн цалин	241,891,149.19	294,847,633.04
210102	Нэмэгдэл	75,530,545.98	74,151,307.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	9,353,798.00	11,825,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,824,219.79</b>	<b>45,701,672.40</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,825,316.86	32,515,269.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,515,557.84	4,977,272.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,618,851.86	1,850,991.77
210204	Ажилгүйдлийн даатгал	520,676.25	1,227,087.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,343,816.98	5,131,052.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,102,216.72</b>	-
210301	Гэрэл, цахилгаан	1,041,887.76	-
210302	Түлш, халаалт	5,500,510.40	-
210303	Цэвэр, бохир ус	1,559,818.56	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>65,000.00</b>	<b>341,000.00</b>
210401	Бичиг хэрэг	-	341,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,000.00	-
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>21,500.00</b>	<b>61,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,500.00	61,250.00
210502	Хоол, хүнс	-	-





210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,713,241.85</b>	<b>21,726,694.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,748,000.00	5,397,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,217,800.00	4,789,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,747,441.85	11,539,494.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,093,283.28</b>	-
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,093,283.28</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,093,283.28	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>139,365,084.47</b>	<b>102,630,587.54</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>139,365,084.47</b>	<b>102,630,587.54</b>






## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан


/төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>537,124,100.00</b>	<b>547,015,300.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>537,124,100.00</b>	<b>547,015,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	513,928,600.00	545,515,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>513,928,600.00</b>	<b>545,515,300.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	513,928,600.00	545,515,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,195,500.00</b>	<b>1,500,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,195,500.00	1,500,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>397,495,212.96</b>	<b>439,239,212.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>397,495,212.96</b>	<b>439,239,212.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>384,401,929.68</b>	<b>439,239,212.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>326,775,493.17</b>	<b>380,824,340.11</b>
210101	Үндсэн цалин	241,891,149.19	294,847,633.04
210102	Нэмэгдэл	75,530,545.98	74,151,307.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	9,353,798.00	11,825,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,824,219.79</b>	<b>45,701,672.40</b>
210201	Тэтгэврийн даатгалын	27,825,316.86	32,515,269.05
210202	Тэтгэмжийн даатгалын	3,515,557.84	4,977,272.36
210203	ҮОМШӨ-ий даатгалын	2,618,851.86	1,850,991.77
210204	Ажилгүйдлийн даатгалын	520,676.25	1,227,087.08
210205	Эрүүл мэндийн даатгалын	5,343,816.98	5,131,052.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>8,102,216.72</b>	-
210301	Гэрэл, цахилгаан	1,041,887.76	-
210302	Түлш, халаалт	5,500,510.40	-
210303	Цэвэр, бохир ус	1,559,818.56	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	-	-
210401	Бичиг хэргийн зардал	-	-
210402	Тээвэр шатахуун	-	-
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	-	-
210404	Ном хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-





210408	Бараа материал акталсны зардал	-	-
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>2,000,000.00</b>	<b>1,500,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>-</b>
210702	Дотоодын томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,700,000.00</b>	<b>11,213,200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,200,000.00	6,267,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	4,946,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,093,283.28</b>	<b>-</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>13,093,283.28</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,093,283.28	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>139,628,887.04</b>	<b>107,776,087.49</b>
	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн		-
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>139,628,887.04</b>	<b>107,776,087.49</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		158,132,205.63
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		265,908,293.12





2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	68,810,168.80	-	208,175,253.27
C02	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	208,175,253.27	-	208,175,253.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн			139,365,084.47		-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	208,175,253.27	-	208,175,253.27
D01	Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	208,175,253.27	-	208,175,253.27
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			102,630,587.54		102,630,587.54
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	310,805,840.81	-	310,805,840.81






## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


/төгрөгөөр/


Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>705,147,600.00</b>	<b>439,239,212.51</b>	<b>(265,908,387.49)</b>	<b>62.3%</b>
21	Урсгал зардлын дүн	705,147,600.00	439,239,212.51	(265,908,387.49)	62.3%
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>705,147,600.00</b>	<b>439,239,212.51</b>	<b>(265,908,387.49)</b>	<b>62.3%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>613,633,800.00</b>	<b>380,824,340.11</b>	<b>(232,809,459.89)</b>	<b>62.1%</b>
210101	Үндсэн цалин	388,351,600.00	294,847,633.04	(93,503,966.96)	75.9%
210102	Нэмэгдэл	205,054,100.00	74,151,307.07	(130,902,792.93)	36.2%
210104	Урамшуулал	20,228,100.00	11,825,400.00	(8,402,700.00)	58.5%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	0.0%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,704,300.00</b>	<b>45,701,672.40</b>	<b>(31,002,627.60)</b>	<b>59.6%</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,158,900.00	32,515,269.05	(19,643,630.95)	62.3%
210202	Тэтгэмжийн даатгал	6,136,300.00	4,977,272.36	(1,159,027.64)	81.1%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,068,200.00	1,850,991.77	(1,217,208.23)	60.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,068,200.00	1,227,087.08	(1,841,112.92)	40.0%
210205	ЭМД-ын хураамж	12,272,700.00	5,131,052.14	(7,141,647.86)	41.8%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	-	100.0%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,309,500.00</b>	<b>11,213,200.00</b>	<b>(2,096,300.00)</b>	<b>84.2%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,309,500.00	6,267,100.00	(2,042,400.00)	75.4%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,946,100.00	(53,900.00)	98.9%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>0.0%</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>				<b>0.0%</b>
	Дотоод эх үүсвэрээр				0.0%
	Тоног төхөөрөмж				0.0%
	Бусад хөрөнгө				0.0%
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>705,147,600.00</b>	<b>547,015,300.00</b>	<b>158,132,300.00</b>	<b>77.6%</b>
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	703,647,600.00	545,515,300.00	158,132,300.00	77.5%
131001	Улсын төсвөөс санхүүжих	703,647,600.00	545,515,300.00	158,132,300.00	





1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-	-	0.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-	-	0.0%
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>	-	<b>100.0%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,500,000.00	1,500,000.00	-	100.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	158,132,205.63	(158,132,205.63)	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	265,908,293.12	(265,908,293.12)	0.0%
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	21.00	-	95.5%
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.0%
	Үйлчлэх ажилтан	5.00	4.00	-	80.0%





### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тус байгууллага насан туршдаа суралцахуйн үнэ цэнэ, тасралтгүй байдлыг бүрдүүлэн, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлж хүний нөөцийг чадавхжуулах, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг хувь хүний онцлогт нийцүүлэн зохион байгуулах, сургалтын үр дүн, чанарыг дээшлүүлэх гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус төв нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,


Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузел сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.



Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102,630.6 мянган төгрөгөөр букуу 49.3 хувиар нэмэгдсэн нь мөнгөн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	158,132.2	265,908.3	107,776.1
Авлага	-	-	-
Бараа материал	13,045.5	13,669.2	623.7
Үндсэн хөрөнгө	36,997.5	31,228.3	(5,769.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>208,175.2</b>	<b>310,805.8</b>	<b>102,630.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	208,175.2	310,805.8	102,630.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>208,175.2</b>	<b>310,805.8</b>	<b>102,630.6</b>

Тайлант онц эцэст төвлөрсөн мөнгөнөөс 11,597.3 мянган төгрөг үлдэж, төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 200,612.6 мянган төгрөг байна.


Бараа материалын дансны үлдэгдэл 13,669.2 мянган төгрөг болж 623.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11,236.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 10,612.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,228.3 мянган төгрөг болж 5,769.2 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-наас сургалтын хэрэгцээнд зориулан 5,770.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг хандиваар авч, 11,539.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 310,805.8 мянган төгрөг болж, 102,630.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 540,107.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 6,000.0 мянган төгрөг, нийт 546,107.6 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвөөс 545,515.4 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 158,132.2 мянган төгрөг буюу нийт төсвийн зарлагыг 703,647.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 1,500.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Энэ нь өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэсэн, цалин хөлс нэмэгдсэнээс цалингийн зардлыг 156,055.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 19,382.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,099.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхдээ улсын төсвөөс 703,647.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 1,500.0 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,500.0 мянган төгрөг, улсын төсвөөс 545,515.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагаандаа 437,739.2 мянган төгрөгийг зарцуулснаар тайлант оны эцэст 265,908.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 439,239.2 мянган төгрөг буюу 62.2 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулав.

д/д	Хөтөлбөр	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		Код	Нэр				
1	81834	2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	613 633,8	380 824,3	232 809,5	62.1 %
2		2102	Нийгмийн даатгал эрүүл мэнд	76 704,3	45 701,7	31 002,6	59.5%
3		2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1500,0	1500,0	-	100.0%
4		2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13 309,5	11 213,2	2 096,3	84.3%
Нийт дүн				705 147,6	439 239,2	265 908,3	62.2%

### 3.5.3 Нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 406,594.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,065.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**


Дархан Уул аймгийн Дархан сумын Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 5 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээнээс 4 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ..." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**


Тус төвийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр баталсан 546,107.6 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 163,540.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 82,176.4 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 62.3 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,942.0 мянган төгрөгийн алдаа зөрчил<sup>1</sup> илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1.Илрүүлэлт:** Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан сургуулийн захирлын үндсэн цалинг 1 дахин нэмэгдүүлж, 2,942.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох зөвлөмж өгөөгүй болно.


Тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурьдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 4.4.2 дахь хэсэгт дурдсан Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тус тус зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл


/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 2,942.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан.	1	2,942.0	-	-	1	2,942.0	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,942.0</b>	-	-	<b>1</b>	<b>2,942.0</b>	-	-	-	-	-	-



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээлэлийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-			1	-
Тус цэцэрлэгийн Ахмадын тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1				1	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>

